



2020 оны 04 дүгээр сарын 24
№16 /1118/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
хууль**

**Санхүүжилтийн хэлэлцээр
соёрхон батлах тухай**

**Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол**

**Журам батлах
тухай**

**Монгол Улсын
олон улсын
гэрээ**

**Монгол Улс болон Олон улсын
хөгжлийн ассоциаци хоорондын
Санхүүжилтийн хэлэлцээр
("Улаанбаатар хотын цэвэр
агаар" төслийн нэмэлт
санхүүжилт)**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

171. Санхүүжилтийн хэлэлцээр соёрхон батлах тухай 797

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

172. Журам батлах тухай Дугаар 392 797

173. Үндэсний хөтөлбөр батлах тухай Дугаар 418 801

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

174. Монгол Улс болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын Санхүүжилтийн хэлэлцээр (“Улаанбаатар хотын цэвэр агаар” төслийн нэмэлт санхүүжилт) 809

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 04 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс, Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан “Улаанбаатар хотын цэвэр агаар төсөл”-ийн нэмэлт Санхүүжилтийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 10 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 392

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Инновацийн тухай хуулийн 6.1.5, 14.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:



1. “Инновацийн төсөл бүртгэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН САЙД**

Ё.БААТАРБИЛЭГ

Засгийн газрын 2019 оны
392 дугаар тогтоолын хавсралт

ИННОВАЦИЙН ТӨСӨЛ БҮРТГЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмаар инновацийн төслийг хүлээн авах, үнэлгээ өгч, дүгнэлт гаргах, мэдээллийн санд бүртгэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Инновацийн төсөл (цаашид “Төсөл” гэх) нь Инновацийн тухай хуульд заасан инновацийн үйл ажиллагааны зарчимд нийцсэн байна.

1.3. Өмчийн хэлбэрээс үл хамааран аж ахуйн нэгж, эрдэм шинжилгээний байгууллага, дээд болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага, төрийн бус байгууллага, иргэн төсөл мэдүүлэх эрхтэй.

Хоёр. Төсөл, түүнд тавигдах шаардлага

2.1. Төслийн мэдүүлэг нь ерөнхий болон үндсэн хэсгээс бүрдэнэ.

2.2. Төслийн ерөнхий хэсэгт дор дурдсан мэдээллийг тусгасан байна:

- 2.2.1. төслийн нэр;
- 2.2.2. төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг;
- 2.2.3. төсөл хэрэгжүүлэх хугацаа (эхлэх, дуусах он, сар, өдөр);
- 2.2.4. инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр, төрөл;
- 2.2.5. төслийн танилцуулга;
- 2.2.6. оюуны өмчийн эрхийн мэдээлэл.

2.3. Төслийн үндсэн хэсэгт дор дурдсан мэдээлэл, баримт бичгийг тусгаж бүрдүүлсэн байна:

- 2.3.1. төсөл бүртгүүлэх тухай албан мэдэгдэл;
- 2.3.2. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ (иргэний үнэмлэх)-ний хуулбар;
- 2.3.3. эрх бүхий байгууллагаас олгосон патент, ашигтай загвар, зохиогчийн эрхийн гэрчилгээний хуулбар;
- 2.3.4. төсөл хэрэгжүүлэх шаардлага, үндэслэл, судалгаа;
- 2.3.5. маркетингийн болон бизнес төлөвлөгөө;
- 2.3.6. үйл ажиллагааны төлөвлөгөө;
- 2.3.7. техник, эдийн засгийн үндэслэл;
- 2.3.8. төсөл хэрэгжүүлэхэд ашиглах техник, технологи, програм хангамж, зураг дизайны тодорхойлолт;
- 2.3.9. бүтээгдэхүүн, үйлчилгээний анхдагч загварыг гаргаж, технологийн туршилт, зүгшрүүлэлт хийсэн талаарх мэдээлэл;
- 2.3.10. зах зээл дээрх ижил төстэй бүтээгдэхүүн, технологи, үйлчилгээтэй харьцуулсан судалгаа;
- 2.3.11. хүний эрүүл мэндтэй холбоотой төсөл хэрэгжүүлэх бол Эрүүл мэндийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасан анагаах ухааны Ёс зүйн хяналтын хорооны шийдвэр;
- 2.3.12. байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх эсэх талаарх холбогдох мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт;
- 2.3.13. татвар болон банк, санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн өр төлбөргүй талаарх тодорхойлолт;
- 2.3.14. бусад шаардлагатай мэдээлэл.

2.4. Төсөл, түүнд хавсаргасан баримт бичгийн үнэн зөв байдлыг төсөл мэдүүлэгч бүрэн хариуцна.

2.5. Төсөл нь Инновацийн тухай хуулийн 14.1, 15.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.

Гурав. Төсөл мэдүүлэх, бүртгэх

3.1. Төсөл мэдүүлэгч нь энэ журмын 2.2, 2.3-т заасан мэдээлэл, баримт бичгийг өндөр технологи, үндэсний инновацийн тогтолцоог бүрдүүлэх, хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цаасаар болон цахимаар ирүүлнэ.

3.2. Төсөлд үнэлгээ өгч, дүгнэлт гаргах мэргэжлийн шинжээчийн ажлын хөлсийг төсөл мэдүүлэгч хариуцна. Шинжээчийн ажлын хөлсийг өндөр технологи, үндэсний инновацийн тогтолцоог бүрдүүлэх, хөгжүүлэх асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

3.3. Төсөл нь Инновацийн тухай хуулийн 14.1, 15.1 дэх хэсэг болон энэ журмын 2.2, 2.3-т заасан шаардлагыг хангасан эсэх талаар Инновацийн



тухай хуулийн 7.1.14-т заасан журмын дагуу мэргэжлийн шинжээч үнэлгээ өгч, дүгнэлт гаргана.

3.4. Өндөр технологи, үндэсний инновацийн тогтолцоог бүрдүүлэх, хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь мэргэжлийн шинжээчдийн үнэлгээ, дүгнэлтэд үндэслэн төслийг мэдээллийн санд бүртгэнэ.

3.5. Мэдээллийн санд бүртгэгдсэн төслийн энэ журмын 2.2-т заасан ерөнхий хэсгийн мэдээллийг өндөр технологи, үндэсний инновацийн тогтолцоог бүрдүүлэх, хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын цахим хуудсаар олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

3.6. Төслийн бүртгэлтэй холбоотой лавлагаа, тодорхойлолтыг Иргэний хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль болон бусад холбогдох хуулийн дагуу өндөр технологи, үндэсний инновацийн тогтолцоог бүрдүүлэх, хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгож болно.

3.7. Энэ журмын 2.2, 2.3-т заасан мэдээлэл, баримт бичиг дутуу, эсхүл өмнө нь мэдээллийн санд бүртгэгдсэн патент, ашигтай загвар, зохиогчийн эрхийн асуудлын хүрээнд боловсруулагдсан нь тогтоогдсон бол төслийг мэдээллийн санд бүртгэхгүй.

Дөрөв. Төслийг бүртгэлээс хасах

4.1. Төслийг дор дурдсан нөхцөлд бүртгэлээс хасна:

4.1.1. төсөл хэрэгжүүлэх хугацаа дууссан;

4.1.2. төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс өндөр технологи, үндэсний инновацийн тогтолцоог бүрдүүлэх, хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгэлээс хасуулах тухай хүсэлт ирүүлсэн;

4.1.3. төсөл нь анх мэдүүлсэн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хэрэгжээгүй нь энэ журмын 5.1-д заасан хяналтаар тогтоогдсон;

4.1.4. төслийн үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдал, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөтэй нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон.

Тав. Төслийн хэрэгжилтэд хяналт тавих

5.1. Төслийн хэрэгжилтийн явц, хугацаа, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлсэн байдал, үр дүнд өндөр технологи, үндэсний инновацийн

тогтолцоог бүрдүүлэх, хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

5.2. Өндөр технологи, үндэсний инновацийн тогтолцоог бүрдүүлэх, хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төслийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавих үүрэг бүхий мэргэжлийн шинжээч ажиллуулж болно.

5.3. Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайланг жил бүрийн 2 дугаар сард багтаан өндөр технологи, үндэсний инновацийн тогтолцоог бүрдүүлэх, хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Зургаа. Бусад

6.1. Төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагааны мэдээллийн нууцлалыг хадгалах, хамгаалах, ашиглахтай холбогдсон харилцааг Төрийн болон албаны нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Хувь хүний нууцын тухай хуулиар тус тус зохицуулна.

6.2. Оюуны өмч эзэмшигчтэй холбогдон үүссэн харилцааг Патентын тухай хууль, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль, Иргэний хуулиар зохицуулна.

6.3. Төсөл бүртгэх үйл ажиллагаатай холбогдон үүссэн маргааныг өндөр технологи, үндэсний инновацийн тогтолцоог бүрдүүлэх, хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүлээн авч шийдвэрлэнэ. Гомдол гаргагч шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 11 дүгээр
сарын 28-ны өдөр

Дугаар 418

Улаанбаатар
хот

Үндэсний хөтөлбөр батлах тухай

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.3, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 10.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.



2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаанд даалгасугай.

3. Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх, үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, гадаад улс, олон улсын байгууллагын зээл тусламжид хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 279 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Ч.УЛААН

Засгийн газрын 2019 оны
418 дугаар тогтоолын хавсралт

АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Ерөнхий мэдээлэл

Ахуйн үйлчилгээ нь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд чухал үүрэгтэй болохын зэрэгцээ хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх өргөн боломжийг бүрдүүлдэг. Монгол Улсад ахуйн үйлчилгээ төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооны үеэс томоохон салбар болон эрчимтэй хөгжиж ирсэн түүхтэй.

Монгол Улсад 2018 оны байдлаар ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 9019¹ аж ахуйн нэгж, иргэн бүртгэлтэй байна. Эдгээрийн 8.2 хувь нь нийтийн халуун ус, 25.2 хувь нь үсчин, гоо сайхан, 20.2 хувь нь хувцас захиалга, засвар, 7.1 хувь нь гэрэл зураг авах, угаах, 1.5 хувь нь хими цэвэрлэгээ, угаалга, 3.0 хувь нь ахуйн электрон, цахилгаан хэрэгсэл засвар, 9.2 хувь нь гутал захиалга, засвар, 11.6 хувь нь гэр ахуйн модон эдлэл захиалга, засвар, 2.2 хувь нь алт, мөнгө, үнэт эдлэлийн

¹ Эх сурвалж: Урьдчилсан гүйцэтгэлээр, Нийслэлийн статистик, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хамтран боловсруулагдсан мэдээлэл

захиалга, засвар, 11.9 хувь нь бусад үйлчилгээний чиглэлээр тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 1. Ахуйн үйлчилгээний салбарын нийт цэгийн тоо

№	Үйлчилгээний чиглэл	Улсын дүн				21 аймаг	Нийслэл
		Нийт цэгийн тоо	Эзлэх хувь	Үүнээс:			
				ААНБ	Иргэд		
1.	Нийтийн халуун ус	743	8.2	286	457	427	316
2.	Үсчин, гоо сайхан	2270	25.2	449	1821	1104	1166
3.	Гэрэл зураг авах, угаах үйлчилгээ	644	7.1	131	513	441	203
4.	Хими цэвэрлэгээ, угаалга	137	1.5	83	54	35	102
5.	Хувцас засвар, захиалга	1818	20.2	304	1514	1223	595
6.	Ахуйн электрон, цахилгаан хэрэгсэл засвар	269	3.0	36	233	225	44
7.	Гутал захиалга, засвар	833	9.2	83	750	631	202
8.	Гэр ахуйн модон эдлэл захиалга, засвар	1035	11.6	170	865	955	80
9.	Алт, мөнгө, үнэт эдлэлийн захиалга засвар	195	2.2	17	178	125	70
10.	Бусад*	1075	11.9	453	622	306	769
	Нийт	9019	100	2012	7007	5472	3547

Засгийн газрын 2014 оны 279 дүгээр тогтоолоор баталсан “Ахуйн үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд 2014-2016 онд нийт 6,3 тэрбум төгрөгний санхүүжилт олгогджээ. Үүний үр дүнд 21 аймгийн 67 суманд “Ахуйн үйлчилгээний төв” шинээр байгуулж, 66 сумын ахуйн үйлчилгээний төвийн барилгыг засварлан шинэчилж, үйл ажиллагаа эрхлэх тав тухтай орчинг бүрдүүлж, иргэдэд үйлчлэх нэгдсэн төвийг байгуулж, 164 сумын ахуйн үйлчилгээний төвд хийх хөрөнгө оруулалтад зарцуулсан бөгөөд өнөөгийн байдлаар 221 төв үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна.

Мөн дээрх хөтөлбөр хэрэгжих хугацаанд 431 удаа мэргэжлийн сургалт, семинар зохион байгуулж, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан,



Сум хөгжүүлэх сан, Зээлийн батлан даалтын сан болон бусад төслийн хүрээнд 2014 онд 2218, 2015 онд 684, 2016 онд 542, нийт 3444 хүний ажлын байрыг шинээр бий болгосон байна.

Гэвч санхүүжилтийн эх үүсвэр хангалтгүй байснаас шалтгаалан 109 сумын ахуйн үйлчилгээний төвийг шинээр барих болон шинэчлэх ажил хийгдээгүй бөгөөд хөтөлбөрт туссан зорилт арга хэмжээ нь хангалттай хэрэгжээгүй байна. Ахуйн үйлчилгээний салбарын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор 2018 онд 21 аймаг, нийслэлд хэлэлцүүлэг зохион байгуулж, салбарын хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэд, хэрэглэгч нийт 10657 хүнийг хамруулсан судалгааг хийсэн. Судалгааны дүнгээс үзэхэд “үйлчилгээний байр, талбайн хангамж дутмаг, үйлчилгээний чанарын түвшин харилцан адилгүй, хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцэхгүй, стандартчилал хангалтгүй, мэргэжилтэй, дадлага туршлагатай ажиллагсад дутагдалтай, хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах тогтолцоо бүрдээгүй, ахуйн үйлчилгээг төрийн худалдан авалтаар дэмжих үйл ажиллагаа хязгаарлагдмал, шинжлэх ухаан, технологийн ололт, инновацийг хангалтгүй нэвтрүүлсэн, салбарын статистикийн мэдээлэл дутагдалтай, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын үйл ажиллагаа тогтворжоогүй” зэрэг асуудал тулгамдаж байна.

Иймд Засгийн газрын 2014 оны 279 дүгээр тогтоолоор баталсан ахуй үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа дууссан, ахуйн үйлчилгээг хөгжүүлэхэд учирч байгаа бэрхшээлийг шийдвэрлэх, аж ахуйн нэгж, төрийн бодлогын түвшинд хийгдэх ажлыг тус тус тодорхойлж боломжоо зөв хуваарилан богино хугацаанд шинэчлэх, салбар хоорондын уялдааг нэмэгдүүлэн ажиллах шаардлагын хүрээнд энэхүү хөтөлбөрийг боловсруулав.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

2.1. Иргэдэд чанартай, стандартын шаардлагад нийцсэн ахуйн үйлчилгээг үзүүлэх, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэхэд ахуйн үйлчилгээний салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилт

3.1. Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ:

3.1.1. салбарын хөгжлийг хангах эрх зүйн орчинг үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох;

3.1.2. бүс, орон нутгийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан ахуйн үйлчилгээний төвийг улс, орон нутгийн төсөв болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулах;

3.1.3. төр, хувийн хэвшлийн түншлэлээр бий болсон ахуйн үйлчилгээний төвийн үйлчилгээ эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх;

3.1.4. салбарын төрийн болон төрийн бус байгууллага, боловсрол, сургалтын байгууллагуудтай хамтран хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, давтан сургаж мэргэжил дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлж, эрүүл ахуйн зохистой дадлыг нэвтрүүлж, ажиллагсдын тогтвортой хөдөлмөр эрхлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх;

3.1.5. ахуйн үйлчилгээний салбарын мэдээллийн сан бүрдүүлэх.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1. Салбарын хөгжлийг хангах эрх зүйн орчинг үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.1. ахуйн үйлчилгээний салбарын ангилал, нэр төрлийг олон улсын жишигт нийцүүлэн тодорхойлох;

4.1.2. салбарын хууль, эрх зүйн баримт бичигт дүн шинжилгээ хийж, шинэчлэх замаар салбарын тогтвортой хөгжлийг хангах;

4.1.3. ахуйн үйлчилгээний ангилал тус бүрээр мөрдөгдөх стандартыг олон улсын стандартад нийцүүлэн шинээр болон шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх;

4.1.4. ажиллагсдын ур чадварын зэрэглэл тогтоох эрх зүйн үндсийг бий болгох;

4.1.5. ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийг үе шаттайгаар ангилж, зэрэглэх;

4.1.6. ахуйн үйлчилгээний салбарын эрүүл ахуй, зохистой дадлын аргачлал заавар боловсруулж, үйлчилгээ эрхлэгчдийн ажлын бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх.

4.2. Бүс, орон нутгийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан ахуйн үйлчилгээний төвийг улс, орон нутгийн төсөв болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулах зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.2.1. ахуйн үйлчилгээний зориулалтаар ашиглаж болох нийслэл, орон нутгийн өмчлөлд байгаа барилга байгууламжийг үйлчилгээ эрхлэгчдэд ашиглуулах нөхцөлийг бүрдүүлэх;

4.2.2. аймаг, нийслэлийн хэрэгцээ, шаардлагад үндэслэн ахуйн үйлчилгээний төвийг шинэчлэх болон шинээр бий болгох;

4.2.3. сум, дүүрэг бүрт халуун усны үйлчилгээг бий болгох;



4.2.4. аймаг, нийслэлийн хэмжээнд “Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг батлуулан, хэрэгжүүлэх;

4.2.5. төвөөс алслагдсан сум, дүүрэгт явуулын ахуйн үйлчилгээг зохион байгуулах;

4.2.6. байгаль орчин, хүний эрүүл мэндэд аюулгүй бүтээгдэхүүн, ахуйн үйлчилгээний нэр төрлийг бодлогоор дэмжих;

4.2.7. ахуйн үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжийг тохирлын үнэлгээнд үе шаттай хамруулах;

4.2.8. улсын хэмжээнд ахуйн үйлчилгээний “Шилдэг төв” шалгаруулах аяныг зохион байгуулж, ахуйн үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх.

4.3. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр бий болсон ахуйн үйлчилгээний төвийн үйлчилгээ эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.3.1. ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээл, зээлийн батлан даалтын үйлчилгээнд хамруулах;

4.3.2. тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг тоног төхөөрөмжийн түрээсийн үйлчилгээ (лизинг)-нд хамруулах;

4.3.3. бүтээмж нэмэгдүүлэх, инноваци, байгаль орчинд ээлтэй технологийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх;

4.3.4. ахуйн үйлчилгээний чиглэлээр дэлхийн хэмжээний өндөр зэрэглэлийн уралдаан, тэмцээнд амжилттай оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх;

4.3.5. үйлчилгээний салбарын олон улсын туршлага судлахад дэмжлэг үзүүлэх;

4.3.6. ахуйн үйлчилгээний чиглэлээр бизнес эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх.

4.4. Салбарын төрийн болон төрийн бус байгууллага, боловсрол, сургалтын байгууллагуудтай хамтран хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, давтан сургаж мэргэжил дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлж, эрүүл ахуйн зохистой дадлыг нэвтрүүлж, ажиллагсдын тогтвортой хөдөлмөр эрхлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.4.1. ахуйн үйлчилгээний мэргэжилтэй ажилтны чадамжийн үнэлгээ тогтоох, баталгаажуулалтын мэргэшсэн үнэлгээчдийг бэлтгэх;

4.4.2. ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг бизнес, менежментийн зөвлөх үйлчилгээ, сургалтад хамруулах;

4.4.3. ахуйн үйлчилгээний ажилтны мэргэжил, ур чадвар олгох ажлыг үе шаттай зохион байгуулах;

4.4.4. ахуйн үйлчилгээний зохистой дадал, ёс зүй, ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах;

4.4.5. салбарын хэмжээнд ажиллаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд сурталчлах, борлуулах цэг бий болгоход төрөөс дэмжлэг үзүүлэх;

4.4.6. өнчин болон хөгжлийн бэрхшээлтэй хөдөлмөрийн насны залуусыг ахуйн үйлчилгээний салбарт ажиллах боломжийг дэмжих;

4.4.7. салбарын хэмжээнд туршлага солилцох, ажил, мэргэжлийн уралдаан, тэмцээнийг төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

4.4.8. ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг мэдээллээр хангах, мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх;

4.4.9. албан бус хөдөлмөр эрхлэгчдийг бүртгэж, төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодын оролцоотойгоор нийгмийн үйлчилгээнд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх.

4.5. Ахуйн үйлчилгээний салбарын мэдээллийн сан бүрдүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.5.1. ахуйн үйлчилгээний салбарын статистик мэдээлэл цуглуулах, боловсруулах тогтолцоог бүрдүүлж, үндэсний статистикийн бүрэлдэхүүнд ахуйн үйлчилгээний салбарын бүлэг үзүүлэлтийг оруулах асуудлыг судалж, шийдвэрлэх;

4.5.2. улсын хэмжээнд ахуйн үйлчилгээний салбарын мэдээллийн нэгдсэн сан, цахим хуудсыг шинээр бий болгох;

4.5.3. иргэд ухаалаг гар утаснаасаа ахуйн үйлчилгээний талаарх мэдээлэл авах аппликейшн бий болгож, хөгжүүлэх.

Тав. Хөтөлбөрийн үр дүн

5.1. Салбарын эрх зүйн орчин сайжирч, ахуйн үйлчилгээний төвүүд шинээр бий болсноор иргэдэд үзүүлэх ахуйн үйлчилгээний чанар, хүртээмж дээшилсэн байна.

5.2. Ахуйн үйлчилгээний төвийн үйлчилгээ эрхлэгчдэд төрөөс тодорхой дэмжлэг үзүүлснээр үйлчилгээний чанар сайжирч, ажлын байр шинээр бий болно.

5.3. Салбарын хэмжээнд мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж, эрүүл ахуйн зохистой дадлыг нэвтрүүлэн ажиллагсдын тогтвортой хөдөлмөр эрхлэх нөхцөл боломжийг бүрдүүлсэн байна.

5.4. Ахуйн үйлчилгээний салбарын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлснээр салбарын статистик тоон мэдээлэл тодорхой болсон байна.



Зургаа. Хөтөлбөр хэрэгжих хугацаа, шалгуур үзүүлэлт

6.1. Хөтөлбөрийг 2020-2024 онд хэрэгжүүлнэ.

6.2. Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр тодорхойлно:

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2018 он	Зорилтот түвшин 2024 он
1.	Үндэсний болон олон улсын стандартад нийцсэн халуун усны төв болон ахуйн үйлчилгээний цэг, салбарын тоо	тоо	9019	10000
2.	Ахуйн үйлчилгээний салбарын ажилтны тоо (шинээр бий болгох ажлын байр)	тоо	22000	32000
3.	Явуулын ахуйн үйлчилгээнд хамрагдсан сум, дүүргийн тоо	тоо	96	165
4.	Сургалт, семинарт хамрагдсан ахуйн үйлчилгээ эрхлэгчийн тоо	Хамрагдагсдын тоо	2100	7800
5.	Олон улсын стандартад нийцсэн шинээр бий болох стандарт (шинэчлэх)	тоо	20	23 (7)
6.	Салбарт үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй нэгжийг бүртгэл мэдээллийн системд хамруулах	Хамрагдалтын хувь	0	100

Долоо. Хөтөлбөрийн хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- 7.1.1. улсын болон орон нутгийн төсөв;
- 7.1.2. олон улсын байгууллага, гадаадын зээл, тусламж;
- 7.1.3. төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;
- 7.1.4. гадаад, дотоодын хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт;
- 7.1.5. Засгийн газрын тусгай сангийн хөрөнгө;
- 7.1.6. хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх хяналт,
шинжилгээ, үнэлгээ

8.1. Ахуйн үйлчилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай бол хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулна.

8.2. Ахуйн үйлчилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэхүү хөтөлбөрийн 8.1-д заасан хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг жил бүрийн I дүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулна.

8.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжид үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль, журамд заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулна.

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

МОНГОЛ УЛС

БОЛОН

ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИ

ХООРОНДЫН

САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛЭЛЦЭЭР

(“Улаанбаатар хотын цэвэр агаар” төслийн нэмэлт санхүүжилт)

ЗЭЭЛИЙН ДУГААР 6493-MN

САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛЭЛЦЭЭР

Энэхүү Хэлэлцээрийг Монгол Улс (“Хүлээн авагч”) болон Олон улсын хөгжлийн ассоциаци (“Ассоциаци”) хооронд “Улаанбаатар цэвэр агаар” төсөл (энэхүү хэлэлцээрийн Хавсралтад тодорхойлсон)-ийн хүрээнд нэмэлтээр хийгдэх үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор байгуулсан ба Хэлэлцээр нь гарын үсэг зурсан өдрөөр баталгаажна. Хүлээн авагч болон Ассоциаци хооронд дараах зүйлсийг хэлэлцэн тохиролцов. Үүнд:



1 ДҮГЭЭР ЗҮЙЛ — ЕРӨНХИЙ НӨХЦӨЛҮҮД, НЭР ТОМЪЁОНУУД

- 1.01. Ерөнхий нөхцөлүүд нь (энэхүү Хэлэлцээрийн Хавсралтад заагдсан) энэхүү Хэлэлцээрт үйлчлэх ба түүний салшгүй хэсэг мөн.
- 1.02. Хэлэлцээрийн агуулгад өөрөөр заагаагүй бол Хэлэлцээрт том үсгээр тэмдэглэгдсэн нэр томъёонууд нь Ерөнхий нөхцөлүүд эсхүл энэхүү Хэлэлцээр, түүний удиртгал болон хавсралтад заасан утгыг илэрхийлнэ.

2 ДУГААР ЗҮЙЛ — САНХҮҮЖИЛТ

- 2.01. Ассоциаци нь Хэлэлцээрийн Хуваарь 1-т тодорхойлсон төслийг (“Төсөл”) санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Хүлээн авагчид Ерөнхий нөхцөлүүдийн дагуу хөнгөлөлттэй зээлд тооцогдох найман сая долоон зуун мянган зээлжих тусгай эрх (ЗТЭ 8,700,000)-тэй тэнцэх (түүнчлэн “зээл” болон “санхүүжилт”) хэмжээний зээл олгохыг зөвшөөрсөн.
- 2.02. Хүлээн авагч энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ийн III дахь хэсэгт заасны дагуу санхүүжилтийн хөрөнгийг зарцуулах боломжтой.
- 2.03. Санхүүжилтийн ашиглагдаагүй үлдэгдэлд тооцогдох хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамжийн дээд хэмжээ жилийн нэг хувийн хагас (1%-ийн 1/2) байна.
- 2.04. Зээлийн ашигласан үлдэгдэлд тооцогдох үйлчилгээний хураамж жилийн нэг хувийн дөрөвний гурав (1%-ийн 3/4) байна.
- 2.05. Зээлийн ашигласан үлдэгдэлд тооцогдох зээлийн хүү жилийн нэг зууны хорин таван хувь (1.25%) байна.
- 2.06. Төлбөр хийх өдөр нь жил бүрийн 4 дүгээр сарын 15 болон 10 дугаар сарын 15-ны өдөр байна.
- 2.07. Үндсэн зээлийг энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 3-т заасан эргэн төлөгдөх хуваарийн дагуу эргэн төлнө.
- 2.08. Төлбөр гүйцэтгэх мөнгөн тэмдэгт АНУ-ын доллар байна.

3 ДУГААР ЗҮЙЛ — ТӨСӨЛ

- 3.01. Хүлээн авагч төслийн зорилго, зорилтуудыг хангах үүргийг хүлээнэ. Үүнтэй холбогдуулан Хүлээн авагчийн зүгээс Хэлэлцээрийн Ерөнхий нөхцөлүүдийн 5 дугаар зүйл болон төслийн гэрээний заалтад нийцүүлэн Төсөл хэрэгжүүлэгч байгууллагаар төслийн хэрэгжилтийг хангуулна.

4 ДҮГЭЭР ЗҮЙЛ — ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ, ЦУЦЛАХ

- 4.01. Энэхүү Хэлэлцээрийн хүчин төгөлдөр болох эцсийн хугацаа нь Хэлэлцээр байгуулагдсан өдрөөс хойш нэг зуун хорин (120) хоногийн дотор байна.
- 4.02. Ерөнхий нөхцөлүүдийн Хэсэг 10.05 (б) заалтын дагуу энэхүү Хэлэлцээрийн хүрээнд Хүлээн авагчийн хүлээх аливаа үүрэг



ХУВААРЬ 1

Төслийн танилцуулга

Төслийн зорилго нь гэр хорооллын хэрэглэгчдийг бохирдол бага ялгаруулдаг халаалтын хэрэгслүүдээр хангах, улмаар хөгжлийн түншүүдтэй хамтран Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор дунд хугацааны зорилтот арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхэд оршино.

Энэхүү төсөл нь үндсэн төсөл болон түүнд орсон дараах нэмэлт өөрчлөлтөөс бүрдэж буй. Үүнд:

А бүрэлдэхүүн хэсэг. Гэр хорооллын нарийн тоосонцрыг бууруулах

- (1) Дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. Үүнд: (а) хорт утааны ялгарлыг бууруулахад чиглэгдсэн арга хэмжээнүүд, тухайлбал, бохирдуулагч бодис ихээр ялгаруулж буй нам даралтын зуухнуудыг буулгах туршилтын төсөл, болон (б) сонгогдсон байршил дахь айл өрх болон дэд байшингуудын дулаан алдагдлыг бууруулах;
- (2) Халаалтын цэвэр технологийн хувилбарууд, агаарын чанарын хяналт, дүн шинжилгээ хийх чиглэлээр болон цэвэр технологи бүхий ахуйн болон нам даралтын зуухыг бий болгох, халаалтын цэвэр хэрэгслийн болон барилга байшингийн стандартыг боловсруулж батлуулах, нүүрсний бус технологийн бусад арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлэх чиглэлээр техникийн дэмжлэг туслалцаа үзүүлэх, олон нийтэд сурталчлан таниулах, мэдлэг түгээх, туршлага солилцох арга хэмжээ, сургалт зохион байгуулах.

Б бүрэлдэхүүн Хэсэг. Улаанбаатар хотын төвийн хэсгийн нарийн тоосонцрыг бууруулах

- (1) Хотын ногоон байгууламжийн дутмаг байдлаас үүдэн гардаг нарийн тоосонцрыг бууруулах:
Хотын ногоон байгууламжийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, дараах чиглэлээр туршилтын төсөл боловсруулан хэрэгжүүлнэ, үүнд: (а) ногоон байгууламжийн чиглэлээр Улаанбаатар хотод хэрэгжиж байгаа хөтөлбөр, арга хэмжээнүүдийг үнэлэн дүгнэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх хувилбарууд болон зөвлөмжийн хэрэгжилтэд үнэлгээ өгөх; (б) Улаанбаатар хотод туршилтаар тарьж ургуулах боломжтой зүлэг мод, ургамлыг ханган нийлүүлэх, тарьж суулгахад дэмжлэг үзүүлэх туршилтын төслийг боловсруулан хэрэгжүүлэх.
- (2) Цахилгаан станцуудын утаа болон үнсэн сангаас ялгарах тоосыг бууруулах арга хэмжээ:

Дараах чиглэлээр техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, үүнд: (а) Улаанбаатар хотын дулааны болон цахилгаан станцуудаас ялгарч байгаа утааны хорт агууламжид хяналт тавих илүү хөгжингүй хяналтын систем суурилуулах; (б) цахилгаан станцуудын үнсэн сангаас ялгарч буй тоосыг бууруулах, тэдгээрийн байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн судалгаа, болон асуудлыг үр ашигтай хэлбэрээр шийдвэрлэх зөвлөмжийг тус тус боловсруулах.

- (3) Төвлөрсөн дулаан хангамжийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ба мэдлэг, чадавх бүрдүүлэх:
- (а) Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн өргөтгөл, засвар шинэчлэлийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах;
 - (б) Төвлөрсөн дулаан хангамжийн бодлого зохицуулалт болон удирдлагын чиглэлээр нэмэлт сургалт зохион байгуулах.
- (4) Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны бодлого боловсруулах техникийн дэмжлэг тусалцаа:
- (а) Улаанбаатар хотын төлбөрийн чадварт нийцсэн орон сууцаар хангах бодлого, хууль тогтоомжууд, бодит үйл ажиллагаанд үнэлгээ өгөх, дэвшүүлсэн бодлогын зорилтын хэрэгжилтийн явцыг үр дүнтэй байгаа эсэхийг үнэлэх, төлбөрийн чадварт нийцсэн орон сууцаар хангадаг олон улсын туршлага, сургамжийг танилцуулах.
 - (б) Улаанбаатар хотын төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны стратеги боловсруулах.

В бүрэлдэхүүн хэсэг. Төслийн удирдлага, хяналт-шинжилгээ, үнэлгээ

Төслийн удирдлага, хяналт-шинжилгээ, үнэлгээтэй холбогдох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.

Г бүрэлдэхүүн хэсэг. Гэр хорооллын сонгосон байршил дахь цахилгаанаар халаах шийдэл

- (1) Дараах үйл ажиллагааг санхүүжүүлнэ. Үүнд: (а) сонгогдсон гэр болон байшин сууцуудад цэвэр технологи бүхий халаалтын хэрэгсэл суурилуулах; (б) сонгогдсон өрхүүдэд хоёр-тарифт цахилгаан тоолуур тавих, цахилгааны сүлжээнд холбох; (в) тоолуураас өрх хүртэл татсан цахилгааны утсыг сайжруулах;
- (2) Халаалтын дэвшилтэт технологи болон холбогдох хөтөлбөрийг боловсруулахад үзүүлэх техникийн тусалцаа, чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа.



ХУВААРЬ 2

Төслийн гүйцэтгэл

I хэсэг. Хэрэгжилтийн зохион байгуулалт

A. Институцийн зохион байгуулалт.

1. Хүлээн авагч нь Ассоциацийн шаардлагад нийцсэн чиг үүрэг бүхий Төслийн удирдах хороог байгуулж, төсөл хэрэгжих хугацаанд шаардлагатай нөөц бололцоогоор хангаж ажиллуулна. Хороог Нийслэлийн Засаг даргын орлогч даргалах ба Ассоциацид хүлээн зөвшөөрөгдөх ур чадвар бүхий бусад гишүүд буюу Хүлээн авагч талын Эрчим хүчний яам, Сангийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, төсөл хэрэгжүүлэгч байгууллагын төлөөллөөс бүрдэнэ. Төслийн удирдах хороо нь төслийн хэрэгжилтийг бодлогын чиглэл, удирдамжаар хангах чиг үүрэгтэй.
2. Хүлээн авагч нь Ассоциацийн шаардлагад нийцсэн чиг үүрэг бүхий Төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулан, төсөл хэрэгжих хугацаанд ажиллуулна. Үүнд: (а) нэгжийг даргалах төслийн зохицуулагч ба (б) төслийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай төслийн ерөнхий удирдлага, худалдан авах ажиллагаа, санхүүгийн удирдлага, хяналт-шинжилгээ, үнэлгээ болон тайлагналт хариуцсан тодорхой орон тоотой байна.

Б. Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын санхүүжилт

Хүлээн авагч төслийн хэрэгжилтийг хангах зорилгоор Ассоциациас баталсан дараах нөхцөл, болзлын дагуу зээлийн хөрөнгийг төсөл хэрэгжүүлэгч байгууллагад бүхэлд нь олгоно. Үүнд:

- (а) Ассоциаци болон Хүлээн авагч тал өөрөөр харилцан тохиролцсоноос бусад тохиолдолд зээлийн хөрөнгийг Ассоциацид хүлээн зөвшөөрөгдөх нөхцөл, болзлын дагуу Төсөл хэрэгжүүлэгч байгууллагад бүхэлд нь олгоно.
- (б) Хүлээн авагч нь Төсөл хэрэгжүүлэгч байгууллагыг төслийн хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх, төслийн зорилтуудыг төлөвлөсөн хугацаанд нь хангахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авах үүрэгтэй.
- (в) Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь төслийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх, саад учруулахуйц аливаа нөхцөл байдал бий болсон даруйд энэ тухай Хүлээн авагчид мэдэгдэх үүрэгтэй.
- (г) Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь Хүлээн авагч талын хүсэлтээр төслийн явц болон төслийн зорилтуудад гарч буй ахицын талаар болон Төсөл хэрэгжүүлэгч нэгж Төслийн хэлэлцээрийн дагуу хүлээсэн ажил үүргээ

хэрхэн гүйцэтгэж байгаа талаар санал бодлоо солилцох үүрэгтэй.

- (д) Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь төслийг хэрэгжүүлэхэд Төслийн хэлэлцээр болон Үйл ажиллагааны гарын авлагыг мөрдлөг болгох үүрэгтэй.
- (е) Хүлээн авагч болон Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь дараах үүргийг харилцан хүлээнэ, үүнд: (i) Төслийн хүрээнд хэрэгжүүлж буй аливаа үйл ажиллагаа байгаль орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй тохиолдолд Ассоциацийн шаардлагад нийцүүлсэн Хамгааллын бодлогын баримт бичгийг боловсруулж, түүний хэрэгжилтэд Хүлээн авагч болон Төсөл хэрэгжүүлэх байгууллага хамтран тогтмол хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, ба (ii) Хүлээн авагч болон Төсөл хэрэгжүүлэх байгууллагаас Ассоциацид хүлээн зөвшөөрөгдөх үзүүлэлтэд үндэслэн тогтмол хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, Хамгааллын бодлогыг түргэн шуурхай хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх үүднээс үйл ажиллагааны зохих журмыг батлан мөрдүүлнэ.
- (ё) Зээлийн хөрөнгөөс төслийн зориулалтаар ашиглаагүй эсхүл энэхүү Хэлэлцээр болон Төслийн хэлэлцээрийн заалтыг зөрчин зээлийн хөрөнгийг ашигласан бол тэрхүү хөрөнгийг Хүлээн авагчид шуурхай буцаан олгох үүрэгтэй.
- (ж) Үйл ажиллагааны гарын авлага болон энэхүү Хэлэлцээрт эсхүл Төслийн хэлэлцээрт заасан заалтууд өөр хоорондоо зөрчилдөх тохиолдолд энэхүү Хэлэлцээрийн болон Төслийн хэлэлцээрийн заалтууд давуу эрхтэй үйлчилнэ.

В. Аюулгүй ажиллагаа, хамгааллын бодлого.

1. Хүлээн авагч нь:

- (а) уг төслийг хэрэгжүүлэхдээ Аюулгүй ажиллагаа, хамгааллын бодлого, Байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөө болон хамгааллын бусад холбогдох баримт бичигт нийцүүлэх ба төслийн хүрээнд хийгдэх аливаа судалгааны ажлын даалгавар, удирдамжийг Хамгааллын бодлогын баримт бичиг болон Ассоциацийн шаардлагад нийцүүлнэ.
 - (б) Ассоциациас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр Аюулгүй ажиллагаа, хамгааллын бодлого, Байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөө эсхүл хамгааллын бусад баримт бичгийг шилжүүлэх, өөрчлөх, хүчингүй болгох, хасах, түдгэлзүүлэх үйлдэл хийхгүй эсхүл бусдад үйлдүүлэхгүй.
2. Хүлээн авагч нь Аюулгүй ажиллагаа, хамгааллын бодлогод заасны дагуу төслийн хүрээнд Байгаль орчин, нийгмийн хамгааллын удирдлагын төлөвлөгөө эсхүл хамгааллын бусад баримт бичигтэй байх ба тэдгээр нь:



- (а) Ассоциацийн шаардлагад нийцсэн хэлбэр, агуулга бүхий байх;
 - (б) Ассоциациас бичгээр зөвшөөрөл олгосноос бусад тохиолдолд Ассоциацид танилцуулж, батлуулсан байх;
 - (в) улмаар орон нутагт танилцуулж, баримтлал болсон байна.
3. Хүлээн авагч нь энэхүү Хуваарийн Хэсэг II-д зааснаас гадна Аюулгүй ажиллагаа, хамгааллын бодлого, Байгаль орчин, нийгмийн хамгааллын удирдлагын төлөвлөгөө болон хамгааллын бусад баримт бичгүүд хэрхэн мөрдөгдөж байгаа талаар мэдээ, мэдээллийг тогтмол цуглуулж, тэдгээрийг төслийн тайлангуудад нэгтгэн Ассоциацид хүргүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг тухай бүр авна.
 4. Дээрх 1 дэх бүлэгт дурдагдсан баримт бичгүүд дэх аливаа зүйл заалт энэхүү Хэлэлцээрийн заалттай зөрчилдөх тохиолдолд Хэлэлцээрийн заалт давуу үйлчилнэ.

Г. Үйл ажиллагааны гарын авлага

1. Хүлээн авагч нь:
 - (а) Төслийг Үйл ажиллагааны гарын авлагын дагуу хэрэгжүүлэх ба/эсхүл хэрэгжүүлэх явдлыг баталгаажуулна;
 - (б) Ассоциациас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр Үйл ажиллагааны гарын авлагыг шилжүүлэх, өөрчлөх, хүчингүй болгох, хасах, түдгэлзүүлэх үйлдэл хийхгүй эсхүл бусдаар үйлдүүлэхгүй.
2. Үйл ажиллагааны гарын авлага дахь аливаа зүйл заалт энэхүү Хэлэлцээрийн болон Төслийн хэлэлцээрийн заалттай зөрчилдөх тохиолдолд энэхүү Хэлэлцээрийн заалт давуу үйлчилнэ.

II хэсэг. Төслийн хяналт-шинжилгээ, тайлагнал ба үнэлгээ

Хүлээн авагч нь төслийн хэрэгжилт, явцад гарч буй ахиц, үр дүнгийн талаар Төсөл хэрэгжүүлэх байгууллагаар улирал бүр тайлан гаргуулж, тухайн улирал дууссанаас хойш хуанлийн гуч (30) хоногийн дотор Ассоциацид хүргүүлэх арга хэмжээ авна.

III хэсэг. Санхүүжилтийн хөрөнгийг зарцуулах үйл явц

А. Ерөнхий зүйл

Ерөнхий нөхцөлүүдийн II дугаар зүйл болон Ассоциациас Хүлээн авагчид хүргүүлэх Ашиглалтын болон санхүүжилтийн зааврын дагуу Хүлээн авагч нь доорх хүснэгт дэх ангилал тус бүрд хуваарилагдсан зээлийн хэмжээ болон хамаарах санхүүжилтийн хувь хэмжээнд нийцүүлэн санхүүжилтийг татан авч Зөвшөөрөгдсөн зардлыг санхүүжүүлж болно.



Ангилал	Зээлийн хөрөнгийн хуваарилалт (ЗТЭ-ээр илэрхийлэгдсэн)	Зардлын санхүүжилтийн хувь хэмжээ (татвар оролцуулсан)
(1) Төслийн А бүрэлдэхүүн хэсэг: татаас, бараа, ажил, зөвлөхийн бус үйлчилгээ, зөвлөх үйлчилгээ болон сургалт	4,050,000	100
(2) Төслийн Г бүрэлдэхүүн хэсэг: бараа, ажил, зөвлөхийн бус үйлчилгээ, зөвлөхийн үйлчилгээ болон сургалт	4,050,000	100
(3) Төслийн В бүрэлдэхүүн хэсэг: зөвлөхийн бус болон зөвлөх үйлчилгээ, үйл ажиллагааны нэмэлт зардал	600,000	100
Нийт дүн	8,700,000	100

Б. Хөрөнгө зарцуулах нөхцөлүүд ба хугацаа

- Дээр дурдсан А хэсгийн заалтуудыг үл хамааран энэхүү Хэлэлцээрийг байгуулсан өдрөөс өмнө гарсан аливаа төлбөрийн зориулалтаар ашиглалт хийхгүй.
- Төсөл дуусгавар болох өдөр 2021 оны 12 дугаар сарын 31 байна.

ХУВААРЬ 3

Эргэн төлөлтийн хуваарь

Төлбөр хийх огноо	Эргэн төлөгдөх үндсэн зээлийн хэмжээ (хувиар илэрхийлэв)*
Жил бүрийн 4 дүгээр сарын 15 ба 10 дугаар сарын 15	
2024 оны 10 дугаар сарын 15-наас эхлэн 2044 оны 4 дүгээр сарын 15 хүртэл	1.65%
2044 оны 10 дугаар сарын 15-наас эхлэн 2049 оны 4 дүгээр сарын 15 хүртэл	3.40%

* Ерөнхий нөхцөлүүдийн 3.05 (б) хэсгийн дагуу Ассоциациас өөрөөр заагаагүй бол дээрх хувь хэмжээ нь эргэн төлөгдөх үндсэн зээлийн хувь хэмжээг илэрхийлнэ.



ХАВСРАЛТ

Нэр томъёо

1. “Авилгын эсрэг журам” гэж Ерөнхий нөхцөлүүдийн Хавсралт дахь 5 дугаар хэсгийг хэрэгжүүлэхэд ашиглах, 2006 оны 10 дугаар сарын 15-нд баталж, 2011 оны 1 дүгээр сарын 1-нд болон 2016 оны 7 дугаар сарын 1-нд тус тус шинэчилсэн “Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк (ОУСБХБ)-ны зээл болон Олон улсын хөгжлийн ассоциаци (ОУХА)-ийн хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилт бүхий төслүүдэд ашиглагдах залилан, авилгаас урьдчилан сэргийлэх журам”-ыг хэлнэ.
2. “Ангилал” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын III.A хэсгийн хүснэгтэд заагдсан ангиллыг хэлнэ.
3. “Байгаль орчин, нийгмийн хамгааллын удирдлагын төлөвлөгөө” гэж Хүлээн авагчийн зүгээс Хамгааллын бодлогод нийцүүлэн боловсруулж, Ассоциацийн зөвшөөрлийг үндэслэн 2018 оны 5 дугаар сарын 17-ны өдөр олон нийтэд нээлттэй болгосон төлөвлөгөөг хэлнэ. Төлөвлөгөөнд эрсдэлийг бууруулах арга хэмжээг тодорхойлж, байгаль орчин ба нийгэмд учруулах сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн, төслийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаанаас шалтгаалан байгаль орчин, нийгэмд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг арилгах, тэдгээрийг орлуулах эсхүл зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл бууруулах үүднээс авч хэрэгжүүлэх, эсхүл эерэг нөлөөллийг бэхжүүлэх арга хэмжээ бүрийг тусгасан, хамгааллын удирдлага, хяналтын бүтэц, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон байна. Ассоциациас урьдчилан бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр төлөвлөгөөнд тухай бүр орсон нэмэлт өөрчлөлт, түүний хавсралт, хуваарь мөн үүнд хамаарна.
4. “Ерөнхий нөхцөлүүд” гэж 2017 оны 7 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан “Олон улсын хөгжлийн ассоциацийн хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн Ерөнхий нөхцөлүүд”-ийг хэлнэ.
5. “Гэр” гэж зөөж тээвэрлэх боломжтой, эсгий дотор бүхий Монголын уламжлалт сууцыг хэлнэ.
6. “Үйл ажиллагааны нэмэлт зардал” гэж төсөлтэй холбоотой гарах зардлуудыг (*төсөл* хэрэгжээгүй тохиолдолд гарахгүй байх зардлууд)-ыг хэлэх ба үүнд албан хэрэгцээнд шаардагдах бичиг хэргийн зардал, дулаан, ус, цахилгааны ашиглалтын зардал, банкны хураамж, мэдээлэл, харилцаа холбооны зардал, олон нийтийн хэвлэл мэдээлэл, хэвлэлтийн зардал, орчуулгын үйлчилгээ, автомашины түрээс, засвар арчилгаа, үйлчилгээ, даатгал, албаны байрны түрээс, барилгын болон тоног төхөөрөмжийн засвар, томилолт, зам хоног болон барилгын болон түр орон тооны ажилтнуудын цалин (Хүлээн авагч талын төрийн албан хаагчдын цалин болон цалингийн нэмэгдэл үүнд хамаарахгүй) зэрэг орно.
7. “Үйл ажиллагааны гарын авлага” гэж Төсөл хэрэгжүүлэх нэгжээс

- Ассоциацийн шаардлагад нийцүүлэн 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдөр батлан, үйл ажиллагаандаа мөрдөж буй, Төслийн хэлэлцээрийн Хуваарийн I дэх Г хэсэгт заасан дараах үйл явц буюу (i) эрх бүхий өрхүүдийг сонгох шалгуур, журам; (ii) халаалтын төхөөрөмжийг хэрхэн түгээх, үүнд мөн санхүүгийн удирдлага, институцийн зохион байгуулалт, хүрээлэн буй орчны хяналт шалгалтын журам; (iii) халаалтын хэрэгсэл, хоёр-тарифт цахилгаан тоолуур худалдан авах, техникийн туслалцаа үзүүлэх зөвлөхүүдийг сонгон шалгаруулах; (iv) хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах шаардлага, (v) төслийн Г бүрэлдэхүүн хэсгийг хэрэгжүүлэхэд шаардагдах гэрээ хэлцэл байгуулах, тэдгээрийг гүйцэтгэх удирдамж бүхий гарын авлагыг хэлнэ. Ассоциациас урьдчилан бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр гарын авлагад тухай бүр орсон нэмэлт өөрчлөлт, түүний хавсралт, хуваарь мөн үүнд хамаарна.
8. “Санхүүжилтийн үндсэн хэлэлцээр” гэж Хүлээн авагч болон Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд 2012 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр байгуулсан (5039-MN зээлийн дугаар бүхий) хэлэлцээр болон түүний нэмэлт, өөрчлөлтийг хэлнэ.
 9. “Үндсэн төсөл” гэж Олон улсын хөгжлийн ассоциацийн есөн сая долоон зуун мянган зээлжих тусгай эрх (ЗТЭ 9,700,000)-тэй тэнцэхүйц Санхүүжилтийн анхны хэлэлцээрийн хүрээнд хэрэгжсэн төслийг хэлнэ.
 10. “Худалдан авах ажиллагааны журам” гэж Ерөнхий нөхцөлүүдийн Хавсралт дахь 87 дугаар хэсэгт зааснаар 2016 оны 7 дугаар сард баталж, 2017 оны 11 дүгээр сард шинэчилсэн “Санхүүжилт, хөрөнгө оруулалтын зээлдэгч нарт зориулсан Дэлхийн банкны Худалдан авах ажиллагааны журам”-ыг хэлнэ.
 11. “Төсөл хэрэгжүүлэгч байгууллага” гэж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрыг хэлнэ.
 12. “Төсөл хэрэгжүүлэх нэгж” гэж төслийн гэрээний Хуваарь дахь I.A хэсгийн 2 дугаар заалтад тусгасан нэгжийг хэлнэ.
 13. “Аюулгүй ажиллагаа, хамгааллын бодлого” гэж Хүлээн авагчаас Ассоциацийн шаардлагад нийцүүлэн 2011 оны 10 дугаар сарын 18-ны өдөр баталж, 2018 оны 5 дугаар сарын 17-ны өдөр шинэчилсэн, энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын I.C хэсэгт заасан баримт бичгийг хэлэх бөгөөд (i) үйл ажиллагаанд шаардлагатай сайн туршлага; (ii) ургамлын хортон шавж, өвчин үүсгэгчийг устгах зориулалттай гербицид болон пестицид ашиглах сайн туршлага болон сэрэмжлүүлэх журам; (iii) төслийн хүрээнд хөрөнгө оруулахаар санал болгосон бүх үйл ажиллагаанд техник, эдийн засгийн судалгаа хийхэд шаардагдах байгаль орчны болон хамгааллын бусад арга хэмжээ; (iv) зуухны шинэ загварыг үйлдвэрлэх болон хуучин зуухнуудыг устгах ажлын нөлөөллийн үнэлгээг хийлгэх ба үүнд байгаль орчны талаас үүсэж болох асуудлууд, шийдвэрлэх арга замын тухай зөвлөмж,



хураан авсан зуухыг хайлуулж боловсруулан дахин ашиглах төлөвлөгөө зэргийг тусгасан аюулгүй ажиллагаа, хамгааллын баримт бичиг; (v) цахилгааны кабел угсралтын болон цахилгаан, хүчдэлтэй холбоотой үүсэх эрсдэл, тухайлбал цахилгаанд цохиулах, өндрөөс унах, цахилгаан соронзон нөлөөлөл зэргийг тооцсон хамгааллын арга хэмжээ зэргийг тусгасан байна. Ассоциациас урьдчилан бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр баримт бичигт тухай бүр нэмэлт, өөрчлөлт оруулах ба үүнд төлөвлөгөөний хавсралт, хуваариуд мөн хамаарна.

14. “Төслийн удирдах хороо” гэж төслийн Хэлэлцээрийн Хуваарийн I.A хэсгийн 1 дүгээр заалтад тусгасан, Ассоциацийн бичгээр ирүүлсэн зөвшөөрлийг үндэслэн тухай бүр бүрэлдэхүүнд нь өөрчлөлт оруулж болох бүтцийг хэлнэ.
15. “Гарын үсэг зурсан өдөр” гэж энэхүү Хэлэлцээрт Ассоциаци болон Хүлээн авагч тал харилцан гарын үсэг зурсан сүүлийн өдрийг хэлэх бөгөөд энэхүү тодорхойлолт нь Ерөнхий нөхцөлүүдэд тусгагдсан «Санхүүжилтийн хэлэлцээрийн огноо» гэсэн нэр томъёонд мөн хамаарна.
16. “Татаас” гэж бохирдуулагч бодисын ялгарлыг бууруулах зорилгоор авч хэрэгжүүлж буй эсхүл шинээр нэвтрүүлж буй арга хэмжээнд оролцох шалгуурыг хангасан айл өрхийн төлөх үнийг бууруулсан мөнгөн дүнг хэлэх ба Үйл ажиллагааны гарын авлагын дагуу төслийн А бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хийгдэх үйл ажиллагааны санхүүжилтийг мөн ойлгоно.
17. “Сургалт” гэж Ассоциациас урьдчилан бичгээр баталсан жилийн төсөвт үндэслэгдсэн, төслийн үйл ажиллагаатай шууд холбогдох сургалт, танилцах аялал, семинар зохион байгуулахад гарах зардал, үүнд материал худалдан авч хэвлүүлэх, хурлын байрны түрээс, сургалтын материал боловсруулах зардал, багшийн төлбөр, сургалт болон танилцах аялалд оролцогчдын тээврийн, байр болон зам хоногийн зардлыг хэлнэ.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiiin_medeleel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.5

Индекс: 200003